

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ

**“ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД
ГОЛ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНҮҮД
ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.”**

АУДИТЫН КОД: ХӨА-2022/44-ШТА-ГА

**ХӨВСГӨЛ АЙМАГ
2022 ОН**

Дарга, тэргүүлэх аудитор **А.Эрдэнэбаатар**
Утас: 88883317 Цахим хаяг: Erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер **Б.Тэгшдэлгэр**
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор **Д.Отгонбаяр**
Утас: 89306788 Цахим хаяг: Otgonbayard@audit.gov.mn

Аудитор **Н.Гүрбазар**
Утас: 92118084 Цахим хаяг: gurbazarn@aufit.gov.mn

Аудитор **Б.Давааням**
Утас: 92113932 Цахим хаяг: davaannyamb@aufit.gov.mn

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.khuvsgul.audit.mn

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
А.Эрдэнэбаатар
Аудитын менежер
Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор
Д.Отгонбаяр
Аудитор
Б.Давааням
Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл гарвал
70384043 дугаарын
утас, 70383793
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум
Аймгийн ЗДТГ-ын “А”
корпус 3 давхар

Цахим хаяг:
audit.mn/?page_id=579

2022 оны 7 дугаар сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

БҮЛЭГ 1. Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд гол нөлөө үзүүлэх зарим арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна.

1.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2021-2024 онд хэрэгжих хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

1.2. Аймгийн ЗДТГ нь сумд, агентлаг, байгууллагыг удирдлага арга зүйгээр хангаж уялдаатай ажиллах нь зүйтэй байна.

1.3. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд гол нөлөө үзүүлэх зарим арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна.

1.4. ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэхээр баталсан орон нутгийн төсөв нь үйлдвэржилт, дэд бүтэц зэрэг томоохон бүтээн байгуулалтад чиглээгүй байна.

БҮЛЭГ 2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрэх үр дүнг тооцож шалгуур үзүүлэлтийн дагуу ХШҮ хийгээгүй байна.

2.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн 13.9 хувь буюу 91-н арга хэмжээний хэрэгжилтийг агентлаг, байгууллагууд бодит гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна.

2.2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй байна.

2.3. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг эрх бүхий байгууллагад танилцуулж, ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлбар
ГА	Гүйцэтгэлийн Аудит
ТАБ	Төрийн Аудитын Байгууллага
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗГ	Засгийн Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ХШУДАХ	Хяналт-Шинжилгээ, Үнэлгээ Дотоод Аудитын Хэлтэс
ЗДҮАХ	Засаг Даргын Үйл Ажиллагааны Хөтөлбөр
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЗУХ	Төрийн Захиргааны Удирдлагын хэлтэс
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ОНХО	Орон Нутгийн Хөрөнгө Оруулалт
ХШҮ	Хяналт Шинжилгээ Үнэлгээ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бүрэлдэхүүн

Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан "Үндэсний аудитын газрын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд" хийлээ.

Аудитын зорилт

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.

Үүнд:

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаж, тогтоосон хугацаанд хяналт үнэлгээ хийсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөлт гүйцэтгэл тайлагнал, хяналт үнэлгээ, 2021 оны төлөвлөлтийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУЕА-ын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитад хамрагдсан байгууллагууд болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, тайланг судалж, нотлох зүйлсийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан нягтлан шалгах, харьцуулалт, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглав.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу хэрэгжүүлсэн горим, сорилыг үнэлж тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох баримт, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Хууль:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

- Бусад холбогдох хууль

Улсын их хурлын тогтоол:

- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүд

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол

- Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоол “аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”
- Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02 дугаар тогтоол “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”

Засаг даргын захирамж:

- Аймгийн Засаг даргын 2017 оны А/709 дүгээр захирамж “Аймгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”
- Аймгийн Засаг даргын 2021 оны А/515 дугаар захирамж “Аймгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитор Б.Давааням, Н.Гүрбазар нар аудитын талбарын ажлыг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдөр эхлүүлж, 2022 оны 7 дугаар сарын 08-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүндрэл бэрхшээл

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, мэдээ баримт материал, тайлбар тодруулга авахад тухайн үед ажиллаж байсан алба хаагчдын дийлэнх нь солигдсон, шилжсэн, чөлөөлөгдсөн зэрэг нь хангалттай мэдээллээр хангагдах нөхцөл боломж хязгаарлагдмал байсан.

Ерөнхий мэдээлэл

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” Хөгжлийн хөтөч нэртэйгээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь:


- Бүх нийтийн хамтын оролцоо, бүтээлч үйл ажиллагаанд суурилсан
- Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын тогтвортой хөгжилд тулгуурласан
- Хүний амьдрах, ажиллах, хөгжих таатай орчин бүрдүүлсэн
- Хүнд суртал, авлигаас ангид, ил тод, нээлттэй, хариуцлагатай засаглалтай
- Иргэнээ дээдлэгч аймаг болж эрчимтэй хөгжил-ийн үндсийг тавих зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 3-н тэргүүлэх чиглэлийн хүрээнд 115-н зорилт, 655-н арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээг бодитой хэрэгжих боломжоор хангах зорилгоор 14-н дэд хөтөлбөрийг улс, орон нутгийн төсөв болон бусад санхүүжилтийн эх үүсвэр буюу нийт 1,287,114.9 сая төгрөгийг зарцуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын тэргүүлэх 3-н чиглэлд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгийг диаграммаар харуулбал дараах байдалтай байна.

АЙМГИЙН ЗДҮАХ-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ /2016-2020 ОН/



- Засаглалын бодлого
- Нийгмийн хөгжлийн бодлого
- Эдийн засаг, орон нутгийн хөгжлийн бодлого

Дүрслэлээс харахад аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын тэргүүлэх чиглэлд зарцуулах нийт эх үүсвэрээс Нийгмийн хөгжлийн бодлогод 11.9%, Эдийн засаг, орон нутгийн хөгжлийн бодлогод 87.3%, Засаглалын бодлогод 0.8%-ийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 95.8% буюу үр дүнтэй хэрэгжсэн гэж үнэлэн хэрэгжилтийг үнэн зөв тайлагнан ажилласан сайн талтай гэж дүгнэсэн байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” нэртэйгээр 6-н тэргүүлэх чиглэлийн хүрээнд 26 зорилт, 284-н арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2021 онд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг 65.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон шалгуур үзүүлэлтэд төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарал алдагдсан, зарим арга хэмжээ нь бодлогын шинж чанартай бус, хянагдахуйц хэв шинжийг алдагдуулсан тул нэмэлт өөрчлөлт оруул гэсэн дүгнэлт зөвлөмж өгөгдсөний үндсэн дээр Улс аймаг орон нутгийн төсөвтэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулж, 723 заалт бүхий хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хянаж, 282 арга хэмжээг шинэчлэн баталж, хэрэгжүүлж ажилласан байна. /эх сурвалж: new.unelgee.gov.mn/

БҮЛЭГ НЭГ. ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ГОЛ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2021-2024 онд хэрэгжих хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу 14-н дэд хөтөлбөрийн хамт 115 зорилт, 655 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Засаг дарга томилогдсоноос хойш 60 хоногт багтаан 221 зорилт, 475 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хүснэгт №1

2016-2030 оны урт хугацааны хөтөлбөр		ЗДҮАХ 2016-2020	
Тэргүүлэх чиглэл			
Нийгэм, хүмүүний хөгжил	Эрүүл мэнд		
	Боловсрол		
	Гэр бүл, хүүхэд залуучууд		
	Хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт		
	Соёл урлаг, спорт		
Эдийн засаг, үйлдвэржилт, хөдөө аж ахуйн хөгжил	Төсөв санхүү		
	Эдийн засаг , хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээ		
	Хүнс хөдөө, аж ахуйн дэд хөтөлбөр		
Хүрээлэн буй орчны тогтвортой байдал, аялал жуулчлалын хөгжил	Байгаль орчин, аялал жуулчлал		
Газрын Харилцаа, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжил	Дэд бүтэц		
	Хот байгуулалт, газрын харилцаа		
Засаглалын бодлого, зохицуулалтын хөгжил	Төрийн алба		
	Хууль, эрх зүй, батлан хамгаалах		
	Гадаад харилцаа		

“Алсын хараа 2050”		ЗДҮАХ 2021-2024	
Бодлого			
Хүний хөгжил	“Ковид-19” Халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого		
	Хүний хөгжил бодлого		
Эдийн засаг	Эдийн засгийн бодлого		
Ногоон хөгжил	Ногоон хөгжлийн бодлого		
Бүс, орон нутгийн хөгжил	Бүс орон нутгийн нутгийн хөгжлийн бодлого		
Ухаалаг Засаглал	Засаглалын бодлого		

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийг "Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр"-тэй, 2021-2024 оны ЗДҮАХ-ийг “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогот-той тус тус нийцүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт **655** зорилт арга хэмжээ, 2021-2024 оны хөтөлбөрт **475** зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Аймгийн ЗДҮАХ-т тусгасан зорилт арга хэмжээ нь хэрэгжихүйц боловч зарим зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг батлаагүй байна. Эх үүсвэр батлаагүй зорилт, арга хэмжээг диаграммаар харуулбал. **Диаграмм №2**



Диаграммаас харахад аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг төлөвлөхдөө 2016-2020 онд 22.3 буюу 146, 2021-2024 онд 9.5 хувь буюу 45-н зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн тусгаагүй байна. Энэ нь аймгийн ЗДҮАХ-ийн зорилт, арга хэмжээ нь хэрэгжихгүй байх үр дагаврыг үүсгэж байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5¹, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11² дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа зорилтод түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй 21 зорилт, арга хэмжээ байна. /Дэлгэрэнгүй жагсаалтыг тайлангийн хавсралт №1-ээр харуулав/

Аймгийн ЗДҮАХ-ийн хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүй дараах зорилт арга хэмжээнүүд байна. **Тухайлбал:** **Хүснэгт №2**

№	Дэд хөтөлбөрийн нэр	Зорилт арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр			
1	“Оюунлаг Хөвсгөл” дэд хөтөлбөр	74. Багшийн хөгжлийг дэмжин урамшуулах замаар массын сургалтын чанар, суралцагчдын төлөвшил, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ	Жил бүр СӨБ-ын , бага, суурь , бүрэн дунд боловсролын багшийг шалгаруулж урамшуулна.
2		75. Сургууль, цэцэрлэгийн сургалтын чанар, суралцагч, хамт олны хөгжил төлөвшил, хүүхдэд ээлтэй байдлын үнэлгээ, сум орон нутгийн хүний хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлнэ.	Жил бүр 3 цэцэрлэг, 3 сургуулийг шалгаруулж захирал, эрхлэгчдийг урамшуулна.
3	“Хөгжилд хүргэх – Дэд бүтэц” дэд хөтөлбөр	355. Мөрөн сумын усан сангийн байгууламжийг өргөтгөж ашиглалтад оруулна	Үйл ажиллагаагаар

¹ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засаг даргын бүрэн эрхэд үл хамаарах асуудал болон хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, үндэслэлгүй зорилт, арга хэмжээг тусгахыг хориглоно.

² Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” гэж орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;

4		356. Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн техникийн шинэчлэл, засвар үйлчилгээг шат дараатай хийнэ	Үйл ажиллагаагаар
5		366. Мөрөн сумын дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбогдоогүй 5,9 дүгээр цэцэрлэг болон бусад байгууллагуудыг холбоно.	Үйл ажиллагаагаар
Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр			
6		174. Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв” байгуулах	
7		257. Жимс жимсгэнэ, цай үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэн импорт орлох бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх.	
8	2021-2024 онд дэд хөтөлбөр батлаагүй.	308. “Хашаандаа сайхан амьдаръя” төслийг хэрэгжүүлэх.	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлоогүй
9		384. Төрийн архивын болон төрийн байгууллагуудын архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмжийг сайжруулах	
10		472. Ханх боомтыг олон улсын боомт болгох гадаад харилцаа, эдийн засгийн үр өгөөжийн урьдчилсан тооцоо, судалгааны ажлыг эхлүүлэх.	

Аймгийн ЗДҮАХ-ийн зорилт арга хэмжээний хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүйгээс зарим төлөвлөсөн арга хэмжээ нь үр дүнд чиглээгүй байна гэж аудитаар дүгнэлээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 онд хэрэгжих 14-н дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд 2015 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон хүрэх түвшнийг 2018, 2020 оны байдлаар үнэлэхээр тодорхойлсон байна.

Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжих үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайд хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг жил тус бүрээр нь тооцож төлөвлөсөн боловч гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4.б³-д заасантай нийцэхгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

1.2. Аймгийн ЗДТГ нь сумд, агентлаг, байгууллагыг удирдлага арга зүйгээр хангаж уялдаатай ажиллах нь зүйтэй байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлан мэдээг авах үедээ л тухайн байгууллагуудтай холбогдож ажилласан байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагуудыг ЗДТГ нь нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг хангалттай зохион байгуулж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/709 тоот захирамжаар баталсан “Хөвсгөл аймгийн захиргааны

³ үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тооцож боловсруулсан байх.

байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, аргачлал”-ын 1.3⁴ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг төрийн захиргаа удирдлагын хэлтэс нэгтгэн тайлагнаж, хэрэгжилтэд ХШҮДАХ нь хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд чиг үүргийн давхардалгүй байна.

ЗДҮАХ-ийн хэрэгжилтийг тайлагнах схемийг зураглалаар харуулбал дараах байдалтай байна. Зураглал №1



Сум, агентлаг байгууллагаас ЗДТГ-ын хэлтсүүдэд хагас жил, жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн тайланг албан тоотоор холбогдох бодлогын хэлтэст, ТЗУХ нь нэгтгэж ХШҮДАХ-т үнэлгээ хийлгэхээр хүргүүлж байна.

1.3. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд гол нөлөө үзүүлэх зарим арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна.

Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 14 дэд зорилтын хүрээнд 655 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж 95.8 хувийн хэрэгжилттэй буюу хангалттай хэрэгжсэн гэж үнэлсэн байна. Гүйцэтгэлийн аудитаар зорилт арга хэмжээнүүдийг хянаж үзэхэд аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна гэж үзлээ.

Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зарим арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй боловч хэрэгжилт хангагдсан гэж тайлагнасан нийт 91-н арга хэмжээ байна. *Тухайлбал:* Хүснэгт № 3

Арга хэмжээний дугаар	Арга хэмжээ	Тайлбар
Бүтээн байгуулалт		
123	“Гэрлэх ёслолын Ордон”-г барьж ашиглалтад оруулна.	Хэрэгжээгүй
160	Хүүхэд залуучуудын паркийг бүрэн шинэчилнэ.	Хэрэгжээгүй
246	Олон улсын спорт бэлтгэлийн бааз барина.	Хэрэгжээгүй
Амьдрах орчны тохижилт		
376	Дугуйн зам байгуулна	Хэрэгжээгүй

⁴ “Нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, хүний нөөцийн чадавхыг сайжруулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, мэргэшил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна”

365	Мөрөн сумын хуучин орон сууцуудыг хэрэглээний халуун усны системд холбоно	<i>Хэрэгжээгүй</i>
375	Дэлгэрмөрөн голын дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ	<i>Хэрэгжээгүй</i>
Дэд бүтэц		
346	“Эрдэнэт-Овоот” чиглэлийн 547км төмөр зам барихыг дэмжин, барилгын ажлыг эхлүүлнэ.	<i>Хэрэгжээгүй</i>
309	Оросын холбооны улсаас шатахуун импортлох ажлыг судалж шат дараатай арга хэмжээ авах.	<i>Хэрэгжээгүй</i>
370	Ханх сумын цахилгаан эх үүсвэрийг дотоодын сүлжээнд холбоно	<i>Хэрэгжээгүй</i>
395	Дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ	<i>Хэрэгжээгүй</i>
530	Байгууллага, иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг Мобайл аппликэшнээр дамжуулан авч, эргэж хариу мэдээлэх систем бий болгоно.	<i>Хэрэгжээгүй</i>
Аж үйлдвэр		
329	Дахин боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.	<i>Хэрэгжээгүй</i>
445	Цагаан нуур, Дэлгэрмөрөн, Эг, Идэр зэрэг томоохон гол, нууруудад загас үржүүлгийн цех, цөөрмийн аж ахуй байгуулах замаар байгалийн усан сангийн загасны нөөцийг нэмэгдүүлж, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр аймгийн хэрэгцээг хангана.	<i>Хэрэгжээгүй</i>
463	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”, “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө” гаргуулан нөхөн сэргээлт хийлгэнэ.	<i>Хэрэгжээгүй</i>

Аймгийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны оны хөтөлбөрт туссан зорилт арга хэмжээ нь 90%-ийн хэрэгжилттэй байгаа хэдий ч бүтээн байгуулалт, амьдрах орчны тохижилт, дэд бүтэц, аж үйлдвэржилттэй холбоотой орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд гол нөлөө үзүүлэх дээрх арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Энэ нь орон нутгийн санхүүгийн эх үүсвэр хангалтгүй байгаатай холбоотой байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.


- Хүн амын эрүүл мэнд, эрт илрүүлгийн ажлыг зохион байгуулах
- Эрүүл мэндийн салбарыг үйл ажиллагаа хүний нөөц, техник хэрэгслийг сайжруулах
- Боловсролын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, иргэдийн боловсрол чиг хандлагыг сайжруулах
- Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр “Гэрэлтүүлэг, камержуулалтын” ажлыг тус тус хийсэн байна.

Аялал жуулчлалыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах зэрэг үйл ажиллагааг хамруулан хэрэгжүүлж ажилласан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт арга хэмжээ нь үр нөлөөтэй хэрэгжсэн гэж аудитаар үзлээ.

1.4. ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэхээр баталсан орон нутгийн төсөв нь үйлдвэржилт, дэд бүтэц зэрэг томоохон бүтээн байгуулалтад чиглээгүй байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 1,287,114.9 сая төгрөгийн төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гэвч үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2020 оны эцэст нийт 108,215.2 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн гэж зөрүүтэй тайлагнасан байна. Графикаар харуулбал.

График №1



(Эх сурвалж: Төлөвлөлтийн санхүүгийн эх үүсвэрийн тоон дүнг аймгийн ИТХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтаас, гүйцэтгэлийг ЗГХЭГ-т тайлагнасан нэгдсэн тайлангаас)

Графикаас харахад ЗДҮАХ-т зарцуулсан төсөв нь төлөвлөсөн дүнтэй харьцуулахад гүйцэтгэл 8.4 хувьтай байгаа нь санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөөгүй, хэрэгжилтийг үнэн зөв тайлагнахгүй байгаатай холбоотой байна.

ЗДҮАХ-ийг холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагын урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан баталсан эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт № 4

Санхүүжилтийн эх үүсвэр	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө
ОНХС	32.0	-	64.4	870.0	2,408.0
ОНХО	-	875.3	-	-	-

ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр ЗДҮАХ-ийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 2017-2021 онд нийт 4,249.7 сая төгрөгийг баталсан байна. Аймгийн ЗДҮАХ-т тусгагдсан нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд гол нөлөө үзүүлэх үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг томоохон арга хэмжээнд төсөв батлаагүй байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээнд 184.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан ОНХО, ОНХС-ийн хөрөнгийг ЗДҮАХ-т тусгагдаагүй арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт № 5

Дэд хөтөлбөр	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө /сая. төг/	Тайлбар
Оюунлаг Хөвсгөл дэд хөтөлбөр	Багш цогц чадамж олимпиад	Залуучуудын оролцоо-Хандлага-Манлайлал”, “Хөвсгөлийн хөгжилд гэр бүлийн оролцоо” үйл ажиллагаа	7.8	ЗДҮАХ-т тусгагдаагүй арга хэмжээг санхүүжүүлсэн
Хөгжилд хүргэх дэд бүтэц	Төлөвлөөгүй	Цагаан-Уул сумын төвийн дулааны шугам сүлжээний ажил	100.0	
Эрх зүйн хөтөч	Төлөвлөөгүй	Прокурорын ажилчдын байрны дээврийн засвар	19.3	
Хамтын оролцоо хариуцлагатай засаглал	Төлөвлөөгүй	“Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны тайлангийн сэтгүүл хэвлэж нийлүүлэх	57.5	
Нийт дүн			184.6	

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт зориулсан баталсан төсвөөс 184.6 сая төгрөгийг ЗДҮАХ-т тусгагдаагүй арга хэмжээнд зарцуулсан байна.

БҮЛЭГ ХОЁР. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГ ТООЦОЖ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДАГУУ ХШҮ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн 13.9 хувь буюу 91-н арга хэмжээний хэрэгжилтийг агентлаг, байгууллагууд бодит гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, агентлагууд ЗДТГ-ын холбогдох хэлтсүүдэд тайлагнаж, хэлтсүүд нэгтгэн ЗДТГ-ын ТЗУХ-д эцсийн байдлаар нэгтгүүлж байна.

ЗДҮАХ-ийн холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага агентлагаас гаргаж ирүүлсэн тайлан мэдээ, холбогдох баримт материалыг нэгтгэн архивын нэгж болгон хадгалаагүйгээс ЗДҮАХ-ийг анхан шатанд үнэн зөв тайлагнасан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна.

Аймгийн ЗДҮАХ-ийн хэрэгжилтийн тайлангаас үзэхэд ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлуудыг холбогдох арга хэмжээнд тусгаж тайлагнаагүй байна. **Үүнд:**

- “Эрүүл иргэн эрхэм баялаг” дэд хөтөлбөрийн 1 арга хэмжээ / 6.0 сая/
- “Оюунлаг Хөвсгөл” дэд хөтөлбөрийн 8 арга хэмжээ / 87.6 сая/
- “Эрх зүйн Хөтөч” дэд хөтөлбөрийн 2 арга хэмжээ /10.0 сая/

Аймгийн ЗДҮАХ-г 1,287,114.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн тайланг хянаж үзэхэд 4-жилийн гүйцэтгэлээр 108,215.2 сая төгрөгийг зарцуулсан гэж тайлагнасан байна. Энэ нь зорилт арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, үйл ажиллагааны үр дүнг бүрэн тайлагнахгүй байгааг харуулж байна.

ЗДҮАХ-ийн хэрэгжилтийг гүйцэтгэлтэй тулган үзэхэд дараах дэд хөтөлбөрүүдийн зарим зорилт арга хэмжээг үнэн зөв тайлагнаагүй байна. Хүснэгтээр харуулбал:

№	Дэд хөтөлбөр	Тухайн байгууллагын тайлагнал		Аудитаар		Тухайн байгууллагын тайлагнал		Аудитаар		Тухайн байгууллагын тайлагнал		Аудитаар	
		100%	70%	100%	40%	70%	40%	100%	40%	100%	40%	100%	40%
1	Эрүүл иргэн	8		-		-		-		-		-	
2	Оюунлаг Хөвсгөл	18		-		2		-		-		-	
3	Хамгаалагдсан хүүхэд	5		3		1		-		-		-	
4	Ажилтай орлоготой	5		-		0		-		-		-	
5	Өв соёл	7		1		3		-		-		-	
6	Оновчтой бодлого хариуцлагатай төсөв	1		-		-		-		-		-	
7	Өрсөлдөх чадвартай тогтвортой эдийн засаг	1		1		-		-		-		-	
8	Хөгжилд хүргэх дэд бүтэц	1		1		-		-		-		-	
9	Цахим газар ногоон төлөвлөлт	2		-		-		-		2		-	
10	Ногоон засаглал Тогтвортой аялал жуулчлал	2		-		1		-		2		-	
11	Хамтын оролцоо хариуцлагатай засаглал	7		2		-		-		5		-	
12	Эрх зүйн хөтөч	4		1		-		-		-		-	
13	Найрсаг Хөвсгөл гадаад харилцаа	-		1		-		-		4		-	
Нийт дүн		61		10		7		13					

Хүснэгтээс харахад ЗДҮАХ-ийн 13.9 хувь буюу 91-н арга хэмжээний хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаагүй байна. Тайланг анхан шатанд нэгтгэж буй аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтсүүд арга хэмжээний хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг гүйцэтгэлтэй тулган хэрэгжилтийг бодитой үнэн зөв тайлагнах нь зүйтэй байна.

Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2021 онд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 14 байгууллага агентлагууд ирүүлснийг ХШҮ-тэй харьцуулан хүснэгтээр харуулбал.

Хүснэгт № 7

№	Агентлаг байгууллагын нэр	Байгууллагын үнэлгээ %-иар	ХШҮ-ний дүн %-иар	Тайлбар
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	91.6	65	Зөрүүтэй
2	Эрүүл мэндийн газар	82.6	62.8	Зөрүүтэй
3	Аймгийн нийтийн номын сан	95.7	70.0	Зөрүүтэй
4	Онцгой байдлын газар	94.0	86.0	Зөрүүтэй
5	Орон нутгийг судлах музей	71.6	58	Зөрүүтэй
6	Нийгмийн даатгалын хэлтэс	100	79.4	Зөрүүтэй
7	Орон нутгийн өмчийн газар	82.5	67.5	Зөрүүтэй
8	Гэр бүл,хүүхэд залуучуудын хөгжлийн газар	82.4	76.4	Зөрүүтэй
9	Газрын харилцаа,барилга, хот байгуулалтын газар	46.8	46.8	Үнэн зөв тайлагнасан
10	Сумдын үнэлгээ	80-99	59.4	Зөрүүтэй

ХШҮ-ний үнэлгээнээс харахад аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэгч ихэнх байгууллага, агентлагууд нь зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бодит гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна. Хэрэгжүүлэгч байгууллагууд зөрүүтэй

тайлагнасан байхад аймгийн ЗДТГ-аас ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээг хүлээн авч буй холбогдох хэлтсүүд хэрэгжилтийн тайланг хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй тулган хянаж аваагүйгээс бүрэн хэрэгжээгүй арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжсэн гэж ТЗУХ-т тайлагнасан байна.

Аймгийн ЗДҮАХ-ийн хэрэгжилтийг байгууллага, агентлагаас ирүүлсэн тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн үнэн зөв тайлагнаж байгаа эсэхэд хяналт тавьж ажил дүгнэх нэг үзүүлэлт болгох нь зүйтэй байна.

Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжилтийг нэгтгэн тайлагнахдаа тусгагдсан зорилт арга хэмжээг зөрүүтэй буюу хамааралгүй /давхардуулан/ зүйл тусгаж тайлагнасан байна. *Тухайлбал:*

- Аймгийн соёл урлагийн байгууллагад дутагдалтай байгаа боловсон хүчнийг бодлогоор бэлтгэх талаар БСШУСЯ, орон нутгийн Далай ван коллежтой хамтран ажиллана. /206 дахь арга хэмжээтэй давхацсан/
- Аймгийн нийтийн номын санг орчин үеийн шинэ технологи тоног төхөөрөмж бүхий мэдээллийн төв болгоно. /220 дахь арга хэмжээтэй давхацсан/

Энэ нь хүрсэн түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан тайлан мэдээг хянаж нэгтгэхгүй байгаатай холбоотой байна.

2.2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжих үйл ажиллагааны хөтөлбөрт 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацааг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон, тус хөтөлбөрт тусгаж өгсөн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны тус хөтөлбөрт ХШҮ хийх хугацааг:

- Эхний шатны хяналт үнэлгээг 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор,
- Эцсийн шатны үнэлгээг 2020 оны эхний хагаст хийхээр тогтоосон байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үнэлгээг 2017, 2019 онд хийсэн бөгөөд 2018 онд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжсэн үйл ажиллагааны хөтөлбөрийг 2020 онд 95.4 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн боловч аймгийн ИТХ-д танилцуулж дүгнүүлсэн тогтоол шийдвэр гараагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7⁵, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1.5⁶ заасантай тус тус нийцэхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу ХШҮ хийсэн холбогдох ажлын баримт, материал байхгүй бөгөөд хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй байна. Энэ нь аймгийн Засаг даргын 2017 оны А/709 “Хөвсгөл аймгийн Захиргааны

⁵ “Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж...”

⁶ хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ нийтлэг журам, аргачлал”-ын 6.1⁷ дахь заалттай нийцэхгүй байна.

2.3. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг эрх бүхий байгууллагад танилцуулж, ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг аймгийн ИТХ-д 2017-2019 онд танилцуулан цаашид хэрэгжих боломжтой гэж дүгнүүлсэн байна. Хүснэгт № 8

№	Огноо	Аймгийн ЗДҮАХ-ийг хэлэлцэн дүгнэсэн байдал			Тайлбар
		Тогтоол шийдвэрийн огноо, дугаар	Үнэлгээний хувь	Үнэлэлт, дүгнэлт	
1	2017	ИТХ-ын 2017.12.04-ний өдрийн №02	55 %	Цаашид хэрэгжих бүрэн боломжтой	-
2	2018	ИТХ-ын 2018.12.05-ны өдрийн №02	75.1%	Цаашид хэрэгжих боломжтой	-
3	2019	ИТХ-ын 2019.12.05-ны өдрийн №01	90%	Цаашид хэрэгжих боломжтой	-
4	2020	-	-	-	ИТХ-аар хэлэлцэн дүгнэсэн анхан шатны баримт байхгүй.
5	2021	ИТХ-ын 2019.12.03-ны өдрийн №04	-	Хангалттай	-

Аймгийн Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн ИТХ-д танилцуулан дүгнүүлсэн баримт материал байхгүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4⁸ заалттай нийцэхгүй байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг ЗГХЭГ-т хуульд заасанд хугацаанд буюу жил бүрийн 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор албан бичгээр хүргүүлэн тайлагнасан байна.

Мөн тайланг цахим хэлбэрээр аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ийн хэлтсийн мэргэжилтэн new.unelgee.mn сайтад зорилт арга хэмжээ тус бүрээр нь хэрэгжилтийг тооцож тайлагнасан байна.

⁷ Захиргааны байгууллага нь бодлогын баримт бичигт тодорхойлсон төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Бодлогын баримт бичигт үнэлгээ хийхдээ хяналт-шинжилгээний мэдээлэлд үндэслэн урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үнэлнэ.

⁸ Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.

ДҮГНЭЛТ:

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2021-2024 онд хэрэгжих хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.
2. Аймгийн ЗДТГ нь сумд, агентлаг, байгууллагыг удирдлага арга зүйгээр хангаж уялдаатай ажиллаагүй байна.
3. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд гол нөлөө үзүүлэх зарим арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна.
4. ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэхээр баталсан орон нутгийн төсөв нь үйлдвэржилт, дэд бүтэц зэрэг томоохон бүтээн байгуулалтад чиглээгүй байна.
5. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн 13.9 хувь буюу 91-н арга хэмжээний хэрэгжилтийг бодит гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна.
6. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй байна.
7. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг эрх бүхий байгууллагад танилцуулж, ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга: Ш.Идэрбаясгаланд

1. Аймгийн ЗДҮАХ-т тусгагдсан нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд гол нөлөө үзүүлэх үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг томоохон арга хэмжээний төсвийг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж хэрэгжүүлэн ажиллах.
2. Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийг ЗДҮАХ-т тусгагдсан арга хэмжээнд зарцуулж байх.

Аймгийн ЗДТГ-ын дарга П.Ариунбат

3. Аймгийн ЗДҮАХ-ийн хэрэгжилтийг байгууллага, агентлагаас ирүүлсэн тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн үнэн зөв тайлагнаж байгаа эсэхэд хяналт тавьж ажил дүгнэх нэг үзүүлэлт болгох нь зүйтэй байна.

Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга Б.Мөнгөн-Эрдэнэд

4. Аймгийн ЗДҮАХ-ийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бодитой тооцож, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөж байх.
5. Аймгийн ЗДҮАХ-ийн зорилт, арга хэмжээний хүрэх түвшнийг оновчтой тодорхойлж төлөвлөх.
6. Аймгийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллах.
7. ЗДҮАХ-ийн зорилт арга хэмжээний тайланг хүрсэн түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлт хангагдсан эсэхийг хянаж тайлан мэдээг нэгтгэж байх.
8. ЗДҮАХ-ийн холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага агентлагаас гаргаж ирүүлсэн тайлан мэдээг холбогдох баримт материалыг нэгтгэн архивын нэгж болгон хадгалж байх.

Аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нарт

9. Тайланг анхан шатанд нэгтгэж буй аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтсүүд арга хэмжээний хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг бодит гүйцэтгэлтэй тулган хэрэгжилтийг бодитой үнэн зөв тайлагнаж байх.

Зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	Өгсөн албан шаардлага		Төлбөрийн акт		Зөвлөмж	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг төлөвлөхдөө 2016-2020 онд 146, 2021-2024 онд 45-н зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгаагүй байна.	-					1	-
2	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт арга хэмжээний хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүй байна.	-					1	-
3	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагуудыг арга зүйгээр хангаж ажиллаагүй байна.	-					1	-
4	“Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 1,287,114.9 сая төгрөгийн төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хөтөлбөрийн гүйцэтгэлийг 108,215.2 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн гэж зөрүүтэй тайлагнасан байна.	-					1	-
5	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 91-н арга хэмжээний хэрэгжилтийг бодит гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан байна.	-					1	-
6	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага агентлагаас гаргаж ирүүлсэн тайлан мэдээг холбогдох баримт материалыг нэгтгэн архивын нэгж болгон хадгалаагүй байна.	-					1	-
7	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг жил тус бүрээр нь тооцож төлөвлөсөн боловч гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.	-	1	-				
8	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ОНХО, ОНХС-д баталсан төсвөөс 184.6 сая төгрөгийг ЗДҮАХ-т тусгагдаагүй арга хэмжээнд зарцуулсан байна.	184.6					1	184.6
9	ЗДҮАХ-ийн зорилт арга хэмжээний тайланг хүрсэн түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан тайлан мэдээг хянаж нэгтгэхгүй байна.	-					1	-
10	Аймгийн ЗДҮАХ-т ХШҮ хийсэн холбогдох ажлын баримт, материал байхгүй бөгөөд	-	1	-				

	хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй байна.							
11	Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээг хүлээн авч буй холбогдох хэлтсүүд хэрэгжилтийн тайланг хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй тулган хянаж аваагүй байна.	-					1	-
	Дүн	184.6	2	-	-	-	9	184.6

Хавсралт №1

Оновчтой тодорхойлоогүй зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт 2016-2020		
№	Зорилт арга хэмжээ	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт
1	74. Багшийн хөгжлийг дэмжин урамшуулах замаар массын сургалтын чанар, суралцагчдын төлөвшил, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ	Жил бүр СӨБ-ын , бага, суурь , бүрэн дунд боловсролын багшийг шалгаруулж урамшуулна.
2	75. Сургууль, цэцэрлэгийн сургалтын чанар, суралцагч, хамт олны хөгжил төлөвшил, хүүхдэд ээлтэй байдлын үнэлгээ, сум орон нутгийн хүний хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлнэ.	Жил бүр 3 цэцэрлэг, 3 сургуулийг шалгаруулж захирал, эрхлэгчдийг урамшуулна.
3	309. Оросын холбооны улсаас шатахуун импортлох ажлыг судалж шат дараатай арга хэмжээ авах	Үйл ажиллагаагаар
4	346. “Эрдэнэт-Овоот” чиглэлийн 547км төмөр зам барихыг дэмжин, барилгын ажлыг эхлүүлнэ	Үйл ажиллагаагаар
5	348. Зорчигч тээврийн авто вокзалыг өргөтгөн, гадна тохижилтыг сайжруулна	Үйл ажиллагаагаар
6	349. Сум хоорондын болон Мөрөн сумын нийтийн тээврийн үйл ажиллагааг сайжруулж, Мөрөн сумын сурагчдад зориулсан нийтийн тээврийг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагаагаар
7	350. Мөрөн Нисэх буудлыг олон улсын нислэг хүлээн авах боломжийг хангаж нислэгийг эхлүүлнэ	Үйл ажиллагаагаар
8	353. Усан замын тээврийн үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ	Үйл ажиллагаагаар
9	355. Мөрөн сумын усан сангийн байгууламжийг өргөтгөж ашиглалтад оруулна	Үйл ажиллагаагаар
10	356. Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн техникийн шинэчлэл, засвар үйлчилгээг шат дараатай хийнэ	Үйл ажиллагаагаар
11	358. Стандартын шаардлага хангасан усаар суурин газрын хүн амын хэрэглээг хангана	Үйл ажиллагаагаар
12	359. Хөдөөгийн хүн амын ахуйн хэрэглээний задгай усны чанар аюулгүй байдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах ажлыг эхлүүлнэ	Үйл ажиллагаагаар
13	360. Мөрөн сумын багуудад холбооны худаг, сувагчлал байгуулна	Үйл ажиллагаагаар
14	362. 2-оос доошгүй сумдыг шилэн кабельд холбож, мэдээллийн техник, технологийн өргөтгөл хийж, хэрэглээг нэмэгдүүлнэ	Үйл ажиллагаагаар
15	363. Хөвсгөл Дулааны станц” ТӨХК техникийн шинэчлэл, засвар үйлчилгээг шат дараатай хийнэ	Үйл ажиллагаагаар
16	365. Мөрөн сумын хуучин орон сууцуудыг хэрэглээний халуун усны системд холбоно	Үйл ажиллагаагаар
17	366. Мөрөн сумын дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбогдоогүй 5,9 дүгээр цэцэрлэг болон бусад байгууллагуудыг холбоно.	Үйл ажиллагаагаар
18	369. Мөрөн сумын тоолуурын нэгтгэл хийгдээгүй хорооллууд болон Цагаан-Уул, Улаан-Уул, Цэцэрлэг сумдад тоолуур нэгтгэлийн ажил хийнэ	Үйл ажиллагаагаар
19	370. Ханх сумын цахилгаан эх үүсвэрийг дотоодын сүлжээнд холбоно	Үйл ажиллагаагаар
20	371. Цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд ойр байгаа багуудыг цахилгааны эх үүсвэрээр (сэргээгдэх эрчим хүчээр хангах) хангах ажлыг хэрэгжүүлж, зарим сумын цахилгаан дамжуулах агаарын 10кВт, 0.4кВт-ын шугам дэд станцыг ашиглалтад оруулж барьж өргөтгөнө	Үйл ажиллагаагаар
21	389. “Түрээсийн орон сууц” – ны талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ	Үйл ажиллагаагаар
Оновчтой тодорхойлоогүй зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт 2021-2024		
22	12. Иргэдэд чиглэсэн гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн хэвлэн түгээх арга хэмжээг зохион байгуулах	Хэвлэмэл гарын авлагын тоо, түгээсэн иргэдийн тоо
23	131. Хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэн биеийн тамирын талбай байгуулах	-
24	174. Хөвсгөл нуурыг түшиглэсэн “Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв” байгуулах	-
25	182. “Хөвсгөлийн гайхамшиг” орон нутгаа сурталчлах нэгдсэн арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулах	-
26	218. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ээлжит тооллогыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах	-
27	257. Жимс жимсгэнэ, цай үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэн импорт орлох бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх.	-
28	308. “Хашаандаа сайхан амьдаръя” төслийг хэрэгжүүлэх.	-

29	384. Төрийн архивын болон төрийн байгууллагуудын архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмжийг сайжруулах	-
30	472. Ханх боомтыг олон улсын боомт болгох гадаад харилцаа, эдийн засгийн үр өгөөжийн урьдчилсан тооцоо, судалгааны ажлыг эхлүүлэх.	-